

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

1. Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/ 3-4

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
12 дугаар сарын 03-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 01 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баярмаа, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Г.Дамдинням, С.Эрдэнэболд;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Баттулга, Б.Баярбаатар, М.Нарантуяа-Нара, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Б.Тулга.

Нэг.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан нар байлцав.

Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлэг Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтаар үргэлжлэв.

Д.Цогтбаатар: 1.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 9
Бүгд: 14
35.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 16 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, ирвэл зохих 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр 16 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
16 цаг 01 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн мэндийг эрье. Одоо маш богинохон хоёрхон асуудал байгаа, тэгээд дуусна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирцэд Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Энхбаярын Батшугар, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар гэсэн гишүүд ирж, 51,9 хувиар ирц бүрдэж, хуралдаан эхэлж байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэг л асуудал байгаа. Засгийн газраас өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 2 хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаарх санал хураалтыг гүйцээн явуулна. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 2 хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаарх санал хураалтыг гүйцээн явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Санал хураалт, байж байгаарай, санал хураалт одоо би.

1.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 28 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад гишүүд бэлдье. Санал хураалтдаа та тэгвэл бэлдчих. Би тэгээд энэ 2 дахь юуг дахиад уншаад танилцуулчихъя. Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 35,7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээр санал хураалт явуулж дууслаа.

16.06 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Оролцсон гишүүддээ талархал илэрхийлье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА